

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 07 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын хороо 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны 77 хувийг халдварт бус өвчин буюу сэргийлж болох өвчлөл, нас баралт эзэлж байна. Хууль санаачлагч хотжилт, үйлдвэржилт, хэт төвлөрөл нь эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдал, химийн бодисын хэрэглээ, агаар, орчны бохирдол, хүний амьдралын буруу хэв маягаас шалтгаалсан өвчлөлд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа амьсгал, зүрх судасны тогтолцоо, хоол боловсруулах замын өвчлөл, хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ дутмаг байгаа хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт зааснаар нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан, шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзсэн тул анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт 50.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай талаар тооцоолол хийгдсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үүрэг, чиглэл хуулийн төсөлд хэрхэн туссан болон хуулийн төслийн хэрэгжиж эхлэх хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нийгмийн эрүүл мэндийн асуудал нь зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал биш, салбар хоорондын зохицуулалтын асуудал тул хуулийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн оролцоог хангах, өвчилсөн хойноо бус өвчнөөс урьдчилан сэргийлэх тал дээр иргэний хүлээх үүрэг, хариуцлагын ямар зохицуулалтууд төсөлд тусгагдсан талаар болон ерөнхий боловсролын сургуулиудын эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.


Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг, санал хэлээгүй бөгөөд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



П.АНУЖИН